

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.09.04

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

2023-2024 оны сумдын өвөлжилт, хичээлийн жилийн бэлтгэл ажил, төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүн, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг шалгаж, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэх зорилготой ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны А/452 тоот захирамжаар томилж 17 сум, 6 тосгонд батлагдсан удирдамжийн дагуу ажиллуулсан.

Аймгийн хэмжээнд төрийн албаны сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилготой төрийн албаны ерөнхий шалгалтын цахим бүртгэлийг 8 дугаар сарын 16-31-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Номгон Форести" ХХК-тай хамтран ажиллах тогтвортой байдлын гэрээ байгуулж, цөлжилтөд өртсөн 154680 га газарт дэвшилтэт технологи ашиглан ойжуулалт хийхэд модны үрсэлгээ нийлүүлэхээр боллоо.

Аймгийн төв Сүхбаатар сумын 7 дугаар багт байрлах барилгын насжилт дууссан 16 айлын орон сууцнуудыг дахин төлөвлөлтөд оруулж шинэ байр бариулахаар шийдвэрлэж, төрийн байгууллага, оршин суугчид, гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл уулзалт хийн харилцан тохиролцлоо. Энэ нь эрсдэлтэй нөхцөлд оршин сууж байсан айл, өрхүүдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, цаашлаад хот дахин төлөвлөлт хийхэд чухал алхам боллоо.

Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төв Сүхбаатар сумын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний гол төвлөрөл бүхий одоогийн 2 эгнээ замыг 4 эгнээ болгон өргөтгөх ажлыг эхлүүлээд байна. Тус ажлыг "Жинчин гранд" ХХК гүйцэтгэж, замын трасс байрлаж байгаа объект, кабель, шугам зэргийг чөлөөлөх ажил хийгдэж байгаа бөгөөд 9 дүгээр сард дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Монгол Улсын баатар Ж.Нэхийтийн нэрэмжит Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн түүхт 90 жилийн ой тохиож эх орныхоо дархан хилийн манаанд зогсож, энэ ангитай ажил амьдралаараа холбогдсон нийт хилчид, ажилтан албан хаагчид, тэдний ар гэр бүлийнхэндээ хүндэтгэл үзүүллээ.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачилсан "Бидний бахархал" төсөл, "Хүүхэд залуучуудад Эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Цэрэг-Эх оронч үзэл, цэргийн хэргийн анхан шатны мэдлэг, дадлага, хүмүүжил олгох "ЗЭВ" төвийн бүсийн сургалт манай аймагт зохион байгуулагдаж Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Дорнод зэрэг 6 аймгийн шилдэг сурагчид хамрагдлаа.

Стандарт, хэмжилзүйн ажил үйлчилгээний талаар:

Сүхбаатар, Мандал, Шаамар сумдын 6 иргэн, аж ахуйн нэгжийн 6 үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж, "MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага", "MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага" стандартын шаардлагад нийцсэн тул баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж тохирлын гэрчилгээ олгосон.

Мандал сумын “Спирт бал бурам” ХХК-ийн 2 нэрийн 5 бүтээгдэхүүнд баталгаажуулалт хийж гэрчилгээ олгосон байна.

Мөн Ерөө суманд “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спэйс” ХХК-ийн олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал- MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн 51 удаагийн тээвэрлэлтэнд баталгаажуулалт хийж, экспортын гэрчилгээ олгосон байна.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 3 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 2 нэрийн 3 стандартын борлуулалт хийсэн байна.

“Дархан-Сэлэнгийн Цахилгаан сүлжээ” ХХК-ийн шинээр суурилуулах 1 болон 3 фазын 702 ш цахилгааны тоолуур баталгаажуулж, итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 15 аж ахуй нэгжийн 48 дээжинд 108 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд объектын гал түймрийн 14, усны осол 2 нийт 16 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 80 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалж ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Их, дээд сургууль, коллеж, Ерөнхий боловсролын сургуулиудын оюутан, сурагчдын дотуур байрны барилга байгууламж”-д Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сүхбаатар, Баянгол, Мандал, Сайхан, Ерөө зэрэг сумд үйл ажиллагаа явуулж буй 36 аж ахуйн нэгж байгууллагын 36 объектод зохион байгуулж 216 зөрчил илрүүлж 5 зөрчлийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 26, албан мэдэгдэл 8-г үйлдсэн.

8 дугаар сарын 10-25-ны өдрүүдэд зохион байгуулсан гүйцэтгэлийн хяналт шалгалтаар шалгавал зохих 36 барилга байгууламж хамрагдаж, илрүүлсэн 211 зөрчлийн 162 зөрчил дутагдал буюу 76.7 хувийг арилгуулсан.

Төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 4 ажлын зургийг хянаж Онцгой байдлын газрын даргаар баталгаажуулан дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн 200,000 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Тайлант хугацаанд 848 баримтаар 9 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэсэн.

Аймгийн 7 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн вэб сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1.	Орон нутгийн төсвийн нийт орлого	62,031,753.4	60,229,653.7	633.3
	Орон нутгийн төсвийн орлого	32,273,465.9	32,165,423.5	99.7
1.1	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	14,779,174.8	7,197,192.0	48.7
	Сумдын төсвийн орлого	17,494,291.1	24,968,231.5	142.7

1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	2,881,993.8	2,781,993.8	96.5
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	10,084,028.0	10,084,028.0	100.0
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	3,458,013.3	3,458,013.3	100.0
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	600,000.0	-	-
1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	846,259.4	694,587.3	82.1
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	1,874,046.6	1,031,661.4	55.0
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		62,031,753.4	41,955,555.8	67.6
Орон нутгийн төсвийн нийт зарлага		62,031,753.4	41,955,555.8	67.6
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		35,371,333.0	26,938,293.6	76.2
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		9,203,932.6	2,840,365.2	30.9
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		17,456,487.8	12,176,897.0	69.8
Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		4,805,894.8	1,265,973.7	26.3
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан		3,752,287.0	3,504,588.0	93.4
Халамжийн сан		102,918.0	89,719.0	87.2
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		7,995,388.0	6,572,523.7	82.2
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		800,000.0	744,092.6	93.0
Улсын төсөвт төвлөрүүлэх орлого		-	-	-
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		28,772,761.9	10,717,301.5	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,709,670.8	4,709,670.8	100.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		16,098,217.2	4,474,213.9	-
Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд		151,999.8	25,333.3	-
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд		-	-	-
Хөрөнгө оруулалтын зардалд		15,946,217.4	4,448,880.6	-
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		7,964,873.9	1,533,416.8	-
Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд		7,736,323.7	1,400,733.2	-
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		198,550.2	117,683.6	-
Усан хангамжийн татаас		30,000.0	15,000.0	-
4. Тусгай сангуудын зарлага		1,874,046.6	1,031,661.4	55.0
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,874,046.6	1,031,661.4	55.0

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2022 – VI	2023 – VI	<u>2023 - VI</u> <u>2022 - VI</u>
-------------------------------------	-----------	-----------	--------------------------------------

1.ХҮНСНИЙ БАРАА				
	Талх, гурил, будаа	1 500	2 200	146.7
	Гурил /Алтантариа, I зэрэг, кг/	1 500	2 250	150.0
	Талх /орон нутгийн, ш/	1 400	2 200	157.1
	Нарийн боов /кг/	4 500	5 000	111.1
	Будаа /кг/	3 300	3 800	115.2
	Элсэн чихэр /кг/	3 200	4 200	131.3
	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	9 500	13 200	138.9
	Үхрийн мах /кг/	12 000	14 900	124.2
	Адууны мах /кг/	8 500	10 200	120.0
	Ямааны мах /кг/	9 000	11 000	122.2
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	8 000	160.0
	Хиам /чанасан, кг/	16 500	15 600	94.5
	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 000	2 300	2.3*
	Сүү /савласан, л/	4 500	4 700	104.4
	Тараг /задгай, л/	1 500	2 900	193.3
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	22 900	91.6
	Айраг /л/			
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	6 000	8 000	133.3
	Өндөг /ш/	350	380	108.6
	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	11 000	10 300	93.6
	Өөхөн тос /кг/	3 000	3 700	123.3
	Шар тос /кг/	25 000	28 500	114.0
	Масло /задгай, кг/	7 500	9 800	130.7
	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	5 000	1 900	38.0
	Лууван /кг/	4 000	2 100	52.5
	Манжин /кг/	3 500	3 100	88.6
	Байцаа /кг/	3 500	3 200	91.4
	Сонгино /кг/	4 000	3 800	95.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	7 600	7 900	103.9
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	4 500	5 800	128.9
2. ШАТАХУУН				
	Бензин А - 80	2 480	2 480	100.0
	Бензин А - 92	2 500	2 500	100.0
	Дизелийн түлш	4 030	3 550	88.1

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Цагдаагийн газар: 2023 оны 08 дугаар сарын байдлаар нийт 561 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 75 (13.3%)-аар буурсан байна. Нийт 21055 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17096 (81.1%)-аар өссөн байна.

Нийт 2657 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс 1018 нь гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, 1639 нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

“Нэг зам-Нэг соёл” аяны хүрээнд “Ээж мод”, “Тужийн нарсны цамхаг”, “Сайханы хөтөл”-ийн дүүжин гүүрэн дээр аяныг сурталчилсан далбааг байршуулж олон нийтэд хүргэсэн. Мөн авто сургуулийн жолооны дамжааны суралцагч нарт “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал” сэдвээр 4 удаа сургалт зохион байгуулж 310 хүнийг хамруулсан.

Крипто валюттай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим орчинд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэгтэй тэмцэх иргэд олон нийтэд энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээллийг бэлтгэж өгөх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн 4 төрлийн мэдээллийг хандалт өндөртэй олон нийтийн цахим хуудсанд байршуулж сурталчилсан. Тайлант хугацаанд залилах гэмт хэргийн шинжтэй 40 гомдол мэдээллээс 30 гомдол мэдээлэл нь цахим орчинд болон бусдын нэр дээр бүртгэлтэй үүрэн холбооны дугаар ашиглаж үйлдсэнээс 8 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 14 гомдол мэдээллийг хуулийн хугацаанд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс: Тайлант хугацаанд шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 99, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо 86, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр эд мөрийн баримтын тоо 36, гэрэл зургийн ажлын тоо 550, криминалистикийн шинжилгээ 6, цогцост хийсэн шинжилгээний тоо 13-ыг тус тус хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 8 дугаар сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 136 /эрэгтэй-77, эмэгтэй-59/
- Гэрлэлтийн бүртгэл - 39
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 14
- Үрчлэлт - 7
- Эцэг, эх тогтоолт – 9 /үүнээс эрэгтэй 3, эмэгтэй 6/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 6
- Нас баралт - 39
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 319
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 119
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 29
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 171
- Гадаад паспорт олголт - 485
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 245 /үүнээс насанд хүрсэн 126, хүүхэд 119/
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 279 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 568
- Анхны бүртгэл - 110
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 127
- Барьцааны гэрээ - 289
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 19
- Лавлагаа хуулбар - 10
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 252

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 621
- Анхны бүртгэл- 41
- Өмчлөх эрх шилжих гэрээ-105
- Барьцааны гэрээ- 451
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 6
- Лавлагаа хуулбар-8
- Нийт бичигдсэн гэрчилгээ-149

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсролын чиглэлээр:

2023-2024 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн суралцахаар Улсын бүртгэлийн газраас ирүүлсэн хамран сургах тойрогт хуваарилах 2074 суралцагчийг харьяа сургуулиудад хуваарилж, 1-р ангийн цахим элсэлтийг зохион байгууллаа.

БШУ-ны Сайдын А/305 дугаар “Арга хэмжээ зохион байгуулах тухай” тушаалаар батлагдсан иргэдийн инновацийн санаачлагыг дэмжих “MON-X” хөтөлбөр 2 дахь жилдээ зохион байгуулагдахаар болсонтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангасан. Хөтөлбөрийн хүрээнд гэрээгээр зөвлөх үйлчилгээ үзүүлэн хамтран хэрэгжүүлж байгаа “Стартап Монгол” ТББ-аас зохион байгуулсан бүс орон нутагт тулгамдаж буй асуудлыг инновац ашиглаж шийдвэрлэх хүсэлтэй бүх насны иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамруулахаар мэдээ, мэдээлэл, гарын авлага, сурталчилгааг түгээн дэлгэрүүлж, сургалт зохион байгуулан ажиллах сургагч багш бэлтгэж байна.

Энэ хичээлийн жилийн бэлтгэл хангах зорилгоор Улаанбаатар хотод бүх шатны боловсролын байгууллагын удирдлагуудад БШУЯ, БЕГ-аас зохион байгуулсан “Боловсролын шинэ сэргэлт-Сургуулийн өмнөх боловсрол” сургалт семинарт 39 цэцэрлэгийн эрхлэгч нарыг хамруулан, мэдээлэл, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/263 тоот тушаалын дагуу энэ улирлын 0-5 хүртэлх насны хүүхэд, амьгүй төрөлтийг магадлах хурал болж Мандал сумын нэгдсэн эмнэлгийн амигүй төрөлтийн нэг тохиолдол болон эхийн ноцтой хүндрэлийн талаар хэлэлцэн, гарсан шийдвэр зөвлөмжүүдийг холбогдох эрүүл мэндийн байгууллага болон Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд хүргүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан EJOB програмд баяжилт хийж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүллээ. Үүнд:

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд - 568 иргэн

Идэвхтэй ажил хайгчаар – 52 иргэн

Ажил зуучлах үйлчилгээнд – 33 иргэн

Ажил олгогчийн мэдээлэл – 21

Сул чөлөөтэй 169 ажлын байр

Шинээр бий болсон 58 ажлын байрыг бүртгэж мэдээллэсэн байна.

Халамжийн чиглэлээр:

Халамжийн санд Улсын төсвөөс тайлант хугацаанд 69507 иргэнд 43214674.3 мянган төгрөгийг олгосон. Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2327 иргэнд 5184353.5 мянган төгрөг

-Нийгмийн халамжийн тэтгэмжид 1852 иргэнд 1872073.0 мянган төгрөг

-Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1651 иргэнд 962422.2 мянган төгрөг

-Жирэмсэн эхийн тэтгэмжид 727 эхэд 195767.6 мянган төгрөг

-0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4218 эхэд 1557905.1 мянган төгрөг

-Ихэр хүүхдийн тэтгэмжид 10 иргэнд 20000.0 мянган төгрөг

-Өрх толгойлсон эхийн тэтгэмжид 225 иргэнд 246383.6 мянган төгрөг

-Ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 2931 ахмадын 291134.9 мянган төгрөг

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 308 иргэний 96796.3 мянган төгрөг

-Алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжид 48 иргэнд 8028.1 мянган төгрөг

-Насны хишиг тэтгэмжид 5800 иргэнд 892430.0 мянган төгрөг

-Эхийн алдар одонгийн тэтгэмжид 9420 иргэнд 1251500.0 мянган төгрөг

-Хүнсний эрхийн бичгийн 1790 иргэнд 155880.0 мянган төгрөг

-Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 38200 иргэнд 30480000.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Халамжийн санд орон нутгийн төсвөөс 310 иргэнд 95372.0 мянган төгрөгийг олгосон. Үүнд:

-Орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 32 иргэнд 38400.0 мянган төгрөг

-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 103 иргэнд 50900.0 мянган төгрөг

-Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 175 иргэнд 6072.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр:

Хүүхдийн тусламжийн 108 утсаар 8 дугаар сарын байдлаар 13 дуудлага бүртгэж (ГБХЗХГ-2, Сүхбаатар сум-2, Мандал сум-8, Сайхан сум-1, Алтанбулаг сум-2), дуудлага мэдээллийг хамтарсан багуудад шилжүүлэн мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16,17 дугаар зүйлийг үндэслэн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг А434 тоот захирамжаар шинэчлэн гаргасан. Хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, эцэг эх олон нийтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр нөлөөллийн ажлыг хийж, нэгдсэн эргүүлийг Сүхбаатар, Ерөө, Алтанбулаг сум, Дулаанхан тосгонд зохион байгуулж гарын авлага, зөвлөмжийг хүргүүллээ. Мөн тус газруудад үер ус болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 самбарыг байршуулсан.

Аймгийн хэмжээнд үер усны улмаас онцгой нөхцөл байдалд Мандал, Шаамар, Сүхбаатар, сумдын 138 өрхийн 293 хүүхэд өртөж үүнээс 70 хүүхдэд хамгааллын үйлчилгээний зардлаас 3.0 сая төгрөгийн дэмжлэг тусалцаа үзүүлсэн.

Гэр бүлийн хөгжлийн чиглэлээр:

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8, Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.3 дахь заалтуудыг үндэслэн Олон улсын “Аавуудын баяр”-ыг угтан “Баярлалаа ааваа” сэдэвт ил захидлыг албан ёсны

фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн, ил захидал илгээсэн хүүхдүүдэд хичээлийн хэрэгслийн багц бэлгэлэх ажлыг зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд 6-18 насны нийт 27 хүүхэд оролцсоноос 70 хувь нь эмэгтэй оролцлоо.

Түр хамгаалах байрны үйл ажиллагаа:

Алтанбулаг сумын түр хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 иргэнд нийгмийн халамж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн мэдүүлгэд оролцож, сэтгэл зүйн анхан шатны тайвшруулах үйлчилгээг үзүүлсэн.

Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр 2 хүүхдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, сэтгэл зүйн тест авч ажилласан.

Залуучуудын хөгжлийн чиглэлээр:

Залуучуудын үндэсний 9 дүгээр чуулганыг угтан Сүхбаатар, Орхонтуул сумд болон Рашаант тосгоны залуучуудын дунд тулгамдаж буй асуудлаар дэд хэлэлцүүлэг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гарааны бизнес эрхлэгч, төрийн бус байгууллагын тэргүүн залуучуудын төвийн ажилтан нарын 4 хүний бүрэлдэхүүнийг тус чуулганд оролцуулсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

Биеийн тамир спортын салбарын анхдугаар зөвлөгөөн, урлаг, спортын наадамд спорт, урлагийн 11 төрлөөр оролцож 2 алт, 2 хүрэл медаль хүртсэн амжилтаар 3 дугаар байранд шалгарсан.

Үндэсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг төв цэнгэлдэх хүрээлэнгийн Сурын талбайд зохион байгуулж, 136 харваачид оролцсоноос 32 нь өсвөрийн харваачид байсан.

Соёл урлагийн чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.дахь хэсэгт “Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээг зохион байгуулна”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан жил болгон уламжлал болгон зохион байгуулагддаг “Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль” арга хэмжээнд оролцсон. Аймгийн хэмжээний соёлын байгууллагуудаас өвлөн уламжлагч, өв тээгч, ардын авъяастнуудыг анхан шатны шалгаруулалт хийж Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд нийт 60 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцлоо.

Аймгийн хэмжээнд нийт 492 өвлөн уламжлагч бүртгэлтэйгээс 424 нь Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлд, 68 нь Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэлтэй байгаагаас 341 нь халх, 24 нь өөлд угсаатан байна.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Ургац тогтоолтын дүнгээр 131.8 мянган га талбайгаас 14.7 цн буюу 193 мянган тонн үр тариа, үүнээс улаанбуудай 126 мянган га талбайгаас 15.6 цн буюу 197 мянган тонн, бусад үр тариа 5.3 мянган га талбайгаас 12 цн буюу 6.3 мянган тонн, тэжээлийн ургамал 17.3 мянган га талбайгаас 12 цн буюу 21.2 мянган тонн, тосны ургамал 51.3 мянган га талбайгаас 5.7 цн буюу 29.2 мянган тонн, төмс 2.3 мянган га талбайгаас 124.5 цн буюу 29.5 мянган тонн, хүнсний ногоо 4 мянган га талбайгаас 132 цн буюу 53.6 мянган тонн ургац хураан авах урьдчилсан баланс гарсан байна.

Энэ намрын ургац хураалтад 426 комбайн, 127 будаа цэвэрлэгч, 133 будаа ачигч, 26 төмсний комбайн, 8 даршны комбайн, 28 төмс ухагч, 23 механикжсан үртрэм, 70 үр сортлогч, 148 хадагч жатка ажиллахад техник засвар үйлчилгээний ажил хийгдэж байна. Техникийн бэлэн байдал 90 хувьтай явагдаж байна.

2023 онд нийт хээлтүүлэгч малын 78,2 хувь буюу 694,7 мянган эх мал төллөж төл бойжилт 95 хувьтай, 512,8 мянган толгой малыг хүнсэнд хэрэгцээлэх, эдийн засгийн эргэлтэнд оруулах урьдчилсан тооцоо гарч 2023-2024 оны өвөл хавар аймгийн хэмжээнд 2,0 сая толгой мал өвөлжих төлөвтэй байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл хүлээн авах цахим системд нийт 26 аж ахуйн нэгж 4,5 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирснээс 6-н төсөл шалгаран дэд хорооны хурлын шийдвэрийг Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлж, 5 аж ахуйн нэгжид 673 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулж, 1 аж ахуйн нэгж нь барьцаа хөрөнгийн асуудлаас болоод одоохондоо зээлээ аваагүй байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн мэдээлэл www.shilen.gov.mn-д аймгийн хэмжээнд нийт 576 зээлдэгчийн 4,6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй мэдээллийг оруулсан.

Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж буй “Алтан намар” өргөтгөсөн худалдаанд 4 дүүргийн 6 цэгт 5-н сумын 45 ногоочин 8-р сарын 16-наас эхлэн борлуулалт хийж эхлээд байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 1.1 сая толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд 872.3 мянган толгой мал, амьтан хамрагдаж 88.4 хувьтай технологит хугацаанд үргэлжлэн явагдаж байна. Үүнд: Гахайн сонгомол мялзан өвчний дархлаажуулалтад 12000 толгой амьтан хамрагдахаас 9879 толгой амьтан хамрагдаж 82.3 хувьтай.

Мал эмнэлгийн нийт 1515 цахим гэрчилгээгээр 18909 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн. Үүнээс өөр аймаг сумруу нийт 12366 толгой мал амьтан явсан, өөр аймаг сумаас нийт 4428 толгой мал, амьтан ирсэн, аймаг дотроо нийт 2115 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн байна.

Маханд эмийн үлдэгдэлийн тандалт хийн, Преми-тестийг ашиглан антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг хүнс болон тэжээлд антибиотикийн үлдэгдлийг илрүүлэх арга MNS 6665:2017 стандартын дагуу 11 сорьц дээж цуглуулан Ampicillin, Penicillin, Chloramphenicol, бүлгийн антибиотик байгааг илрүүлэх шинжилгээг хийж, уг бүлгийн антибиотууд зөвшөөрөгдөх хэмжээнээс бага буюу сөрөг дүнтэй байгааг тогтоосон. Сант суманд мал эмнэлгийн цахим гэрчилгээгүйгээр Увс аймгаас орж ирсэн 59 толгой үхрийг хорио цээрийн дэглэмд оруулж, хариуцлага тооцсон.

Орон нутгийн өмчийн газрын чиглэлээр: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 тоот тогтоолын дагуу тодотгон цахим системд байршуулж Сангийн ямаар батлуулан олон нийтэд нээлттэй ил тод мэдээлсэн.

17 сумын төсөв тодотгох иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолын худалдан авах ажиллагаа зохион байгуулах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг хянан баталгаажуулж Сангийн яаманд хүргүүлжээ.

Захиалагчаас ирүүлсэн ажлын даалгавар, зураг төсвийн дагуу 79 ажлын тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, гэрээ байгуулах эрх олгосон 58, үйлчилгээнд үнэлгээ хийх шатандаа 6, үйлчилгээг хүлээн авах шатандаа 11, үйлчилгээнээс төсөв буцаах 4 ажил, захиалагчаас зураг төсөв ирүүлээгүй 19 ажил байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийж гүйцэтгэж буй Сайхан, Орхон сумдын ойн зурвасын усалгааны эх үүсвэрийг гшийдвэрлэх зорилгоор гүний худаг гаргах ажлын явцтай танилцаж ойн зурвасуудыг цаашид сумын агропаркийн зориулалтаар ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.

Орхон сумын Нарангийн булаг гэх газар цөөрөм байгуулахаар ажлыг эхлүүлж, Орхон, Орхонтуул сумд нь манай аймгийн усны хомсдол бүхий сумдын тоонд ордог тул онцгойлон анхаарч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтад заасан нөхцөл үүссэн тул “Монголын анчдын нийгэмлэг” ТББ-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж ажиллаж байна.

Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор байгуулсан шороон зурвасын арчилгааны ажлын гүйцэтгэлийг Түшиг, Алтанбулаг сумдын нутагт байгуулсан шороон зурвасын арчилгаа, санхүүжилт, ажлын явц гүйцэтгэлийг шалгаж, Хилийн цэргийн 0243 дугаар ангитай хамтран зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд 42 амралтын газрын үйл ажиллагаанд ариун цэврийн байгууламжаас үүдэлтэй хөрсний бохирдлын байдалд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай 02, 03, 04 албан даалгаврын холбогдох заалтын хэрэгжилтийг хангуулах, хүрээлэн буй орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, зөвлөмж, зөвлөгөөг хүргүүлсэн.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр: Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээтэй газарт шинээр газар эзэмших тухай хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлт, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай хүсэлт гаргасан 21 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлт, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай 6 иргэний хүсэлт, нэгж талбар нэгтгэх тухай 3 иргэний хүсэлтийг хүлээн авч нийт 114 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажилласан.

Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах тухай 13 иргэний хүсэлтийг хүлээн авч, Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн, эрхийг шилжүүлэн шийдвэрлэсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 7 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээж, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг шинэчилсэн байна.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг банк болон санхүүгийн байгууллагад барьцаалах хүсэлтийн дагуу 16 иргэний 16 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээнд бүртгэл хийж ажилласан.

Зургаа. Сүм орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сүм:

Аймгийн төсвийн 280,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар ногоон байгууламжийг тохижуулах ажлыг “Бүлээн Оргил” ХХК гүйцэтгэж хүлээлгэж өглөө.

Мөн сумын малын хөлийн татвараар төвлөрсөн 19.378.343 төгрөгийн хөрөнгө оруулалтаар мал угаалгын ванн хүлээж авах ажил хийгдлээ.

8 дугаар сарын 11-ний өдөр Ерөө суманд зохион байгуулагдсан Мах, ноосны чиглэлийн Суффолк үүлдрийн хонины аж ахуйн танилцуулага өдөрлөгт сумын төлөөллүүд оролцож суффолк хонины онцлог шинж чанар, ашиг шим, маллагаа, тэжээл, хэрэгцээний эрлийзжүүлэг, анхаарах зүйлс зэрэг олон талын мэдээлэл солилцон ажилласан.

Монгол Улсын Газрын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2, 53.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 02 тоот албан даалгаварыг тус тус үндэслэн сумын 111 иргэнд хадлангийн газрыг ашиглуулах гэрээ байгуулсан.

Тус сумын 3-р багийн Засаг даргын санаачилгаар “Таныг сонсьё” арга хэмжээг 8 дугаар сарын 16-ны өдөр 60 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулж төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэлээ.

Баруунбүрэн сум:

Үр тариа, төмс хүнсний ногооны ургацын урьдчилсан тогтоолтын ажлын хэсэг тариалсан талбай бүрт ажиллаж урьдчилсан ургацыг тогтоосон. Энэ жилийн хувьд тариаланчид технологит хугацаандаа тариалалт болон ургалтын үеийн арьчилгааг хийснээс гадна бороо хур элбэг байгаа тул сумын хэмжээний ургац гуурстай талбайд 15 цн, уринштай талбайд дунджаар 20 цн-ээс дээш байгаа нь сумын дунджаар нэгж га талбайгаас 18 цн ургац буюу 20,066 тонн улаан буудай хураан авахаар урьдчилсан дүн гарсан байна.

Мөн төмс, хүнсний ногооны тариалалт энэ жилийн хувьд 38 иргэн 30 га талбайд төмс, 37 га талбайд хүнсний ногоо тариалж ургацын урьдчилсан дүнгээр төмс нэгж га талбайгаас 80 цн буюу 240 тонн, хүнсний ногоо 90 цн буюу 333 тонн ургац хураан авахаар урьдчилсан дүн гарсан.

Сортын хянан баталгаа хийлгэх аж ахуй нэгж, иргэдийн судалгааг авахад нэг аж ахуй нэгж хүсэлт өгсөн. Мөн бордооны урамшуулалд хамрагдах аж ахуй нэгж, иргэдэд мэдээлэл өгч цахим системд мэдээллийг оруулж урашуулалд хамрагдах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Мал эмнэлгийн тасгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуулалтын арга хэмжээнд Боом, Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийгдэж эхлээд байна.

8 сарын байдлаар цахим бүртгэлийн нэгдсэн системд хүнсэнд адуу-84 толгой, үхэр-276 толгой, хонь-588 толгой, ямаа-375 толгой нийт-793 толгой, адууны мах-1065 кг, үхрийн мах-1150 кг, хонины мах-1890 кг ямааны мах-1410 кг нийт-4480 кг мах, толгой-381 ширхэг тус тус бичигдсэн байна.

8 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд Ивэн 1-р багийн Амарбаясгалант хийдийн Гонгорын бумбаны тахилгын үйл ажиллагааг зохион байгуулж, арга хэмжээний үеэр гарсан нийт 132.3 м3 хог хаягдлыг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт булж дарах ажил хийгдсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн хяналт шалгалтын удирдамжийн дагуу тус суманд үйл ажиллагаа эрхэлдэг амралтын газар, жуулчин бааз, гэр кемп, шатахуун түгээх станцуудын ариун цэврийн байгууламжууд стандартын шаардлага хангаж буй эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж тухай бүрт заавар зөвлөгөөг өгч ажиллалаа.

2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд тус сумын ойн сангаас түлшний мод бэлтгэлийн ажил явагдаж Орхон, Сайхан сумын иргэдийн түлшний мод бэлтгэлд хяналт тавьж 30 иргэний 118м3 мод, модон материалын тээвэрлэлтэнд хяналт тавин, гарал үүслийн гэрчилгээнд баталгаажуулалт хийсэн.

Цахим тоон гарын үсгийг 66 иргэнд олгож, нийт өссөн дүнгээр 641 иргэнд олгосон байна.

Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан операторын горимоор үзүүлэх үйлчилгээг e-mongolia.mn хаягаас нийт 129 иргэн 129 лавлагаа мэдээлэл, e-business.mn хаягнаас 6 аж ахуйн нэгж тоон гарын үсгээр 7 лавлагааг авсан.

Аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Уусан бол бүү жолоод", "Хамгаалах бүс", "Хамгаалах малгай" зэрэг аяныг сумын нутаг дэвсгэрт зохион

байгуулж иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Баянгол сүм:

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас АНУ-д үйл ажиллагаагаа явуулдаг Мандухай циркийн (Mission Mandukhai) хамт олонтой хамтран “Циркийн урлагаар дамжуулан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аян”-ыг зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн ойлголт, мэдлэгийг олгож, гарын авлага, материалыг тарааж ажиллалаа.

Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж ургац хураалтын урьдчилсан тооллого хийхэд 1 га-аас 15 цн ургац авахаар тогтоосон. Мөн аймгийн ХХААГ-ын бүрэлдэхүүн “Түмэн хараа” ХХК, “Бялхам ивээл” ХХК, “Галуут Оюу” ХХК, “Нямбайгаль даваа” ХХК-иудын тариалсан талбайгаар хэмжилт хийж, тариалалтын мэдээтэй тулган ургацыг урьдчилсан байдлаар тогтоосон.

Малчид болон бүхий иргэдэд өөрсдийн өвөлжөө, хаваржааны засвар үйлчилгээг хийх, сүргийн эргэлтийг хийж, ашиг шим муу, хөгшин, тарга хүч муутай малаа заазлах, тариалангийн талбайд нутаглаж байгаа малчдад малаа оруулахгүй байх, байнгын хариулагатай байлгах талаар сануулга зөвлөмж өгөн ажиллаж байна.

Монгол Улсад эмнэлэг, мал үржлийн алба үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ХХААХҮЯ-тай хамтран Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төвд үржүүлж байгаа суффолк үүлдрийн хонины эх сүргийн аж ахуйтай танилцах өдөрлөгт оролцох малчны судалгаа, цахим номонд оруулах материал, хадлан техникийн хэрэгслийн бэлэн байдлын судалгаа, Улс, аймгийн аварга малчдыг судалгаа зэргийг гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

Тайлант хугацаанд “Хүнсний худалдаа эрхлэгчид болон нийтийн хоолны газруудад хяналт шалгалт хийх” тухай удирдамжийн хүрээнд бөөний төв-1, мини маркет-9, хүнсний дэлгүүр-6, мухлаг-6, зоогийн газар-1, цайны газар-1, түргэн хоол-1 нийт 25 объектод хяналт шалгалтыг хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Аймгийн ХХААГ-ын бүрэлдэхүүн 8 дугаар сарын 23-ны өдөр манай суманд ажиллаж, төлөвлөгөөт хуваарийн дагуу Бэст хүнсний бөөний төв, Инээмсэглэл мини маркетууд эрсдлийн үнэлгээ хийж, хяналт шалгалтыг хийлээ.

Хоршоог хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 11 зээлдэгчийн 7,6 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

Ерөө сүм:

Сумын Засаг даргын 2023 оны А/217 тоот “Хадлан бэлтгэх тухай” захирамжийн хүрээнд өрхийн хэрэглээний зориулалтаар 272 иргэний хүсэлтийг хүлээн авч түүнээс 94 иргэнтэй хадлан бэлтгэх гэрээ байгуулсан.

“Төгөлдөр -Ерөө” ОНӨААТҮГ-тай хамтран сумын Тавин, Буурагчин багийн төвийн гэр хорооллын гудамж хоорондох замын хотгор гүдгэрийг тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Уг ажлын хүрээнд нийтдээ 20 гудамжинд 362 машин шороо асгаж тэгшилсэн.

Тавин багийн Улаан булгийн малчдын бүлгээс Соёлын төвтэй хамтран “МАЛЧДЫН ӨДӨРЛӨГ”-ийг зохион байгуулж олон жил мал малласан ахмад малчдадаа хүндэтгэл үзүүлэн, их нас, дааганы уралдаан, бөхийн барилдаан /насанд хүрэгчид болон хүүхдийн/, холимог волейбол, хөгжилтэй буухиа, өв соёлын тэмцээн зэрэг урлаг, спортын арга хэмжээг зохион байгууллаа.

Шилэн данс, tender.gov.mn сайт, ЗДТГ-ын мэдээ цахим хаягаар дамжуулан 4 видео, мэдээллийн шинжтэй 7 пост, анхааруулга шинжтэй 5 пост, нийт 16 мэдээллийг хүргэж 25 сэтгэгдэл, 1200 хариу үйлдлийн хандалт авсан байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 156,000,000 төгрөгийн өртөгтэй “Багш хөгжлийн төвийн тохижилт”-ын ажлыг “Ариун дээж” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгсөн.

Сумын Засаг даргын 2023 оны А/230 дугаар захирамжаар “Ургац тогтоох ажлын хэсэг” байгуулж, 13394,6 га талбайд ургац тогтоолтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ургацын урьдчилсан балансаар улаан буудай 8399 га-гаас 14,7 цн /мөндөрт цохиулсан 150 га/, бусад үр тариа 154 га-гаас 13,5 цн, малын тэжээл 75 га-гаас 15 цн, рапс 4766,6 га -гаас 10,4 цн, төмс 51,6 га-гаас 516 тн, хүнсний ногоо 60,3 га-гаас 630,3 тн тус тус хураан авахаар тогтоосон байна.

Сумын Засаг даргын 2021 оны А/171 дугаартай захирамжаар баталсан “Суралцагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг олгох журам”-ын хүрээнд “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ийн Баянгол сангийн хөрөнгө оруулалтаар Тавин багаас 6, Буурагчин багаас 8, Бугант тосгоноос 9, нийт 23 оюутныг хамруулж нэг хүүхдэд 1,956,000 (нэг сая есөн зуун тавин зургаан) мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг олгохоор шийдвэрлэсэн.

Монголын Залуучуудын өдрийг тохиолдуулан “Ерөөгийн Залуусын Нэгдэл”-ээс санаачлан “Sports Day” арга хэмжээг 18-35 насны залуусын дунд зохион байгуулж давхардсан тоогоор 20 багийн 104 тамирчин амжилттай оролцлоо.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2023 оны 85 тоот тогтоолыг үндэслэн баталсан хуваарийн дагуу ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийг ойн цэвэрлэгээний ажлаар 46 иргэнд олгосон байна.

Жавхлант сум:

Тус сумын Бумбат 1, Моностой 2 дугаар багууд 8 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд сайн үйлсийн аян өрнүүлэх, хүчит бөхийн барилдуулах, хурдан морины уралдуулах, азтан тодруулах, гар бөмбөг, гүйлт, караоке дууны тэмцээнүүд зохион байгуулах зэргээр иргэдийн идэвх оролцоог хангаж “Багийн өдөрлөг”-ийг амжилттай зохион байгууллаа.

Мөн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Засаг даргын нэрэмжит сумын аварга шалгаруулах “Адуучин” тэмцээн болж өндөрлөлөө.

Сумын Засаг даргын санаачилгаар Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Уньтын рашаан сувилалд ахмадын хорооны 47 ахмад настныг 3 өдөр амралтад амраах ажлыг зохион байгуулсан.

Тайлант хугацаанд аймгийн ОНХСангийн 173,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Сургуулийн дотуур байрны гадна пассат, цонхны засварын ажил”-ыг 100 хувийн гүйцэтгэлтэй, аймгийн Замын сангийн 289,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хатуу хучилттай авто зам” тавих ажил 50 хувийн гүйцэтгэлтэй, сумын ОНХСангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “ЗДТГазрын их засварын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй, 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Соёлын төвийн урлагийн хувцас нэмэгдүүлэх” ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тус тус хийгдсэн.

Малын тоо толгойн албан татвар, болон Олон улсын төсөл хөтөлбөр, бусад хөрөнгө оруулалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

-Гэмт халдлага гамшгаас хамгаалах /Цагдаагийн албанд авто машин худалдан авах/-25,000,000 төгрөг. Гүйцэтгэл-100%

-Малын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд /Ариутгал халдваргүйтгэл хийх автомат ДҮК машин худалдан авах/-84,000,000 төгрөг. Гүйцэтгэл-100%

-Стрийм төслийн хүрээнд мод жимсний үржүүлгийн ажил. /1000 ш улиас 1000ш бургас таригдсан. Үрээр- агч, буйлс, гүйлс, шар хуайс/ Гүйцэтгэл 100%

-Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас Жавхлант суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах-20,000,000 төгрөг. Гүйцэтгэл 30%

-Хүлэмж 8*60 м 2ш өөрийн хөрөнгө 10,000,000 төгрөг. Гүйцэтгэл 100%

- Дотуур байранд ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТАНХИМ-ыг ДЗОУБ-ын 8,400,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулах ажил. Гүйцэтгэл 100%
- Ажилчдын байр дотор засварын ажил-10,000,000 төгрөг Гүйцэтгэл 100%
- Усан сан өөрийн хөрөнгөөр-10,000,000 төгрөг. Гүйцэтгэл 100%

Усан хангамж, дулааны системийг тохируулан засварлаж, байгууллагын эзэмшлийн цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийж, инженерийн шугам, сүлжээ, таг нээлхийд осол аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.

Халаалтын үйл ажиллагааг хариуцсан гэрээт байгууллага “Мон Жим” ХХК-д өвөлжилтийн бэлэн байдалд засвар үйлчилгээ тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар албан тоот хүргүүллээ.

2023 онд 6505 га талбайд улаан буудай, 2160 га талбайд тосны ургамал, 260 га талбайд тэжээлийн ургамал, 360 га талбайд төмс, хүнсний ногоо тариалсан. 08 дугаар сарын 18-23-ны өдрийн ургац тогтоолтоор улаан буудай нэгж га талбайгаас 13.5 цн буюу нийт 9300 тонн, тэжээл тосны ургамал нэгж га талбайгаас 12-15 цн буюу нийт 830 тонн, төмс хүнсний ногоо 3960 тонн ургац тус тус хураан авах төлөвтэй байна.

Зүүнбүрэн сүм:

Аймгийн Засаг даргын 2023 оны “2023-2024 оны өвөлжилтийн бэлтэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 02 тоот албан даалгавар, сумын Засаг даргын 2023 оны “2023-2024 оны өвөлжилтийн бэлтэл хангах сумын ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн дагуу төр төсвийн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцлаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/156 дугаар захирамж, сумын Засаг даргын “Хоггүй цэвэрхэн Зүүнбүрэн” аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах тухай А/42 тоот захирамжаар сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн 6 байгууллагын 38 албан хаагч, хувийн хэвшлийн 15 аж ахуйн нэгжийн 60-аад ажилтан, 10 ойн нөхөрлөлийн 22 гишүүд, Төрийн болон Хаан банкны 4 ажилтан, 2 ШТС-ын 3 ажилтан, Жаргалант, Бэлчир, Мангирт багийн 130-аад иргэд “Хоггүй Зүүнбүрэн” аяны хүрээнд сар бүрийн 2 дахь 7 хоногийн Баасан гарагт нийтийн зам талбай болон байгууллагуудын ойр орчмын 19,8га газарт цэвэрлэгээ хийж хэвшээд байна. Нийт 9 удаагийн хог цэвэрлэгээгээр давхардсан тоогоор 260-аад иргэн, 36 автомашин хамрагдаж 75,8тн хог хаягдлыг сумын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлсэн.

Сумын Засаг даргын захирамжаар бруцеллез өвчний дархлаажуулалтыг 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд “Энхбүрэн сүрэг”, “Оюутсүрэг” Мал эмнэлгийн үржлийн нэгжүүдтэй хамтран шуурхай зохион байгуулан ажиллаж байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээнд сумын мал эмнэлгийн үржлийн нэгж болох “Энхбүрэн сүрэг” 29000, “Оюутсүрэг” 24600 нийт 53600 толгой мал хамруулахаас 34840 толгой мал хамруулж 65 хувийн гүйцэтгэлтэй, лабораторийн шинжилгээнд “Энхбүрэн сүрэг” 193 толгой хамруулахаас 201 толгой буюу 104 хувиар, “Оюутсүрэг” 284 толгой хамруулахаас 300 толгой 105 хувиар нийт 477 толгой хамруулахаас 485 толгой хамруулж 102 хувийн гүйцэтгэлтэй байна.

Паразиттах өвчнөөс эмчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд “Энхбүрэн сүрэг” 127045 толгой, “Оюутсүрэг” 88179 толгой тус тус хамруулахаас нийт дүнгээр 40892 толгой буюу 19 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улаанбуудай, үр тариа, тос, тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногооны ургацын балансийг урьдчилан тогтоох ажлыг зохион байгуулж улаанбуудайн дундаж ургац 16,1 цн буюу 14708,1 тн, бусад үр тариа 15,1 цн буюу 1155,1 тн,

рапс, төмс 94,8 цн буюу 237 тн, хүнсний ногоо 120 цн буюу 3663 тн хураан авах төлөвтэй байна.

Сумын малчин, мал бүхий иргэдэд хадлангийн газар олгох ажлыг зохион байгуулж, 200-аад иргэнд хадлангийн зориулалтаар ашиглуулах газар олгон гэрээ хийж, малын албан татвараар 41,371,750 төгрөг, хог хаягдлын хураамж 2,448,000 төгрөгийн сумын төсөвт төвлөрүүлээд байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор 200 гаруй боодол өвсийг гэрээлээд байна.

Мандал сум:

Албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийт 105 мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж, давхардсан тоогоор мэдээ мэдээлэл, видео бичлэгийг 82,360 иргэний хандалтын үзүүлэлттэй байна.

Зүүнхараа Сангийн аж ахуйн түүхт 100 жилийн ойн хүрээнд Хэрх захирагчийн алба дараах бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

-Хэрх Холбоотолгой хэсэгт угтан үдэх хаалга шинээр хийсэн

-Атар-60 жилийг гэрэлт гудамж болгон шинээр хийсэн

-Захирагчийн албаны гадна талын талбайг тохижуулсан

-Төв зам дагуух гэрэлтүүлгийн доор нэмэлт өнгийн гэрэл байршуулсан

-Зүүнхараа САА-н түүхт 100 жилийн ойн газар тариалангийн техникийн парад зохион байгуулсан

-Нийтийн 00 2-г байршилд байршуулсан

-Захирагчийн албаны хажуу талд нийтийн ахуйн үйлчилгээний байр барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн

-Бүх нийтийн хог цэвэрлэгээг Хоггүй орчин-Бидний гэр уриалган дор 3 удаа зохион байгуулж 7 хэсгийн 120 иргэн, аж ахуй нэгжийг хамруулж хамтран ажиллалаа

Хэрх захирагчийн алба төрийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд хүрч үйлчлэх ажлын хүрээнд төр, төсвийн 5 байгууллагатай хамтран Билүүт хөдөөгийн хэсэгт амьдарч буй 55 иргэнд мэдээ, мэдээлэлийг хүргэн, хүрч үйлчилсэн.

Хүнсний манлай үйлдвэр “Спирт бал бурам” ХХК-ийн түүхт 50 жилийн ойн баяр наадам 08 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд болж, 9 насны морьдын уралдаан, Улс аймгийн цолтой 128 хүчит бөхийн барилдаан, халх сурын харваанд Улс, аймгийн цолтой нийт 400 гаруй харваачид цэц мэргэнээ сорьж, шагайн харваанд 160 гаруй харваачид хүрэлцэн ирж цэц мэргэнээ сорин наадсан.

БНСУ-ын Чаннён сум болон Мандал сум хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Саемаул нийгэмлэгийн төлөөлөгчид 13,14-ний өдрүүдэд айлчлан, ажил хэргийн нөхөрсөг уулзалтыг хийлээ. Уулзалтын хүрээнд тус нийгэмлэгийн зүгээс боловсрол, байгаль орчин, хүмүүнлэгийн чиглэлээр цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллах тал дээр санал солилцож “Тэрбум мод” аянд нэгдэн мод тарьж, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн спортын танхимд дэмжлэг үзүүлэн хувцас хэрэглэл хандивлаж, зорилтот бүлгийн 2 өрхөд 5 ханатай гэр гардуулан өгч, малчин өрхийн аж амьдралтай танилцлаа.

8 дугаар сарын 22-ны өдөр Засаг даргын Тамгын газрын урд Соёмбот талбайд АНУ-д үйл ажиллагаагаа явуулдаг "Мандухай" циркын хамт олон хүрэлцэн ирж иргэд, хүүхэд багачуудад циркийн үзүүлбэр үзүүллээ. Тус хамт олон нь “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-тэй хамтран ажилладаг бөгөөд хүчирхийллийн эсрэг ард иргэдийг уриалан сурталчилж, ухуулга материал тараалаа.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж нийт 34 иргэний өргөдлийг шийдвэрлэлээ. Үүнд: байнгын асаргааны тэтгэмжид ахмад настан шинээр хамрагдах-14, сунгалт-6, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр-1, сунгалт-2, байнгын асаргаа шаардлагатай хүүхэд сунгалт-3, тэжээгчийн тэтгэвэр шинээр-5,

сунгалт-1 иргэнийг тус тус хамруулахаар шийдвэрлэв. Ахмад настны тухай хуулийн дагуу протез, ортопедийн хэрэгсэл шаардлагатай 38 ахмад, магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд амарсан 12 ахмадад нийт 7,1 сая төгрөгийн хөнгөлөлтийг олголоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу протез ортопедийн хэрэгсэл шаардлагатай 6 иргэнд 780,0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлэв.

Тайлант сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд нийт 96 /Мандал-88, Түнхэл-3, Хэрх-5/ өрхийн 275 том хүн, 291 хүүхдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлдэг 5 дэлгүүрээр 6728,0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олгож тайланг хугацаанд нь олголоо. Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох шинэчлэгдэн батлагдсан журмын дагуу ehalamj.mn программаар дамжуулан сумын хэмжээний 9600 хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олголоо. Өнгөрсөн сард 1-6 сарын тэтгэмжээ аваагүй хүүхдүүдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нөхөж олгосонтой холбоотойгоор 220 хүүхдэд давхардал үүссэн.

Байгаль орчин хамгаалах ажлын хүрээнд бичил уурхайн PlanetGOLD Монгол төсөл нь хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд агаарын мэргэжлийн дрон гардуулан өгснөөр эвдэрсэн газрууд болон бичил уурхайн талбайн байршил тогтоох, солбицлыг шинэчлэн бүртгэх, байгаль орчны төдийгүй эрэн хайх аврах ажиллагаа бусад болзошгүй эрсдэлээс сэргийлэх нөхцлийг бүрдүүллээ.

2023 оны ургацын урьдчилсан дүнгийн баланс тогтоохоор сумын үр тариа, төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 10 гаруй иргэн, 35 аж ахуй нэгж байгууллагын тариалангийн талбайгаар ажлын хэсэг ажиллалаа. Алтан намар 2023 үзэсгэлэн худалдаанд 20 өрхийн тариаланч иргэдэд мэдээлэл чиглэл өгч Plant.mofa.gov.mn цахим системд бүртгэл хийсэн.

7 дугаар сард үер усны аюулаас болж эвдэрсэн гүүрийг сэргээн засварлах ажил 30 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Орхонтуул сум:

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийг эрчимжүүлэх, цахим үндэстэн болох зорилт, зарласан жилийн хүрээнд иргэдийн оролцоотой цахим орчинд хөгжицгөөе уриатай ажиллаж байна. ИТХ-ын 12 дугаар ээлжит хуралдаанаар “Шинэ төрсөн хүүхдэд хүндэтгэл үзүүлэх”, “Өрх бүр нэг мод”, “Соёлч өрх” хөтөлбөрүүдийг тус тус боловсруулан батлууллаа.

Сумын веб сайтад болох Orkhontuul.se.gov.mn цахим хуудас, сумын ЗДТГ Рашаант тосгон захирагчын алба фейсбүүк хуудсанд цаг үеийн зөвлөмж, мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. Голуудын усны түвшин богино хугацаанд нэмэгдэх, хуурай сайр, гуу жалгаар үер буух нөхцөл бүрдэж болзошгүй тул үер, усны аюулаас сонор сэрэмжтэй байхыг анхааруулж постер мэдээллийг байнга оруулж байна.

8 дугаар сарын байдлаар Нийгмийн халамжийн сангийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 52 иргэнд 16,585,484 мянган төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 38 иргэнд 10,450,0 мянган төгрөг, цалинтай ээж 0-3 насны хүүхдээ асарч байгаа 57 эхэд 2,775,806 мянган төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж 5 эхэд 200,000 мянган төгрөг олгосон.

Тосгоны хэмжээнд 625 хүүхдэд 62,500,0 мянган төгрөг олгосон байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах эрх үүссэн өрхүүдэд үйлчлэх дэлгүүрээр “Цогт баялаг эрдэнэ” ХХК дэлгүүрийг сонгон, гэрээ байгуулан, дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Тайлант хугацаанд хүнсний талоноор өрхүүдэд батлагдсан 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг үнийн саналын дагуу 6 өрхийн 27 иргэнд 360,0 төгрөгийн хүнсийг олгож, холбогдох мэдээ тайланг цаг хугацаанд хүргүүлж ажилласан

Аймгийн ХХҮГ-н дэргэдэх ахмадын сувилалд Рашаант тосгоноос нийт 6 ахмадыг 10 хоног амраасан. Шинээр 2 ахмад нэмэгдэж насны хишигтээ

хамрагдсан. УБТЗ-ын 5-р хэсэгт түр замчинаар ажилд орсон 1 иргэнийг шинэ ажлын байраар, 1 иргэнийг ажил хайгчаар бүртгэсэн.

“Орхонтуул сум Хамтарсан баг” Фэсбүүк хуудсаар дамжуулан Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, тогтоомж, Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зөвлөмж, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх шторк мэдээллийг тогтмол түгээн иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. 108 дуудлагын утсанд энэ сард дуудлага бүртгэгдээгүй байна.

Тайлант хугацаанд Хоршоо хөгжүүлэх санд 306271 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зарласан Баянцогт 2-р багийн 1 орцтой орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Гонирын зам” ХХК-тай гэрээ байгуулан ажил эхлүүлэх зөвшөөрөл авах шатанд явагдаж байна. Мөн Баянцогт 2-р багт Хүнсний ногооны зорь барих ажлын гүйцэтгэгч Кенорда ХХК-тай гэрээ байгуулан ажиллаад байна.

Баянцогт 2-р багийн 1 орцтой орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих, Баянцогтын 2-р багт Бэлчээрийн худаг гаргах, Орхонтуул сумын Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг, Ариутгалын багаж хэрэгсэл худалдан авах ажлуудын нээлт хийгдээд байна.

Орхон сум:

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргын “2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 02 тоот албан даалгаврын дагуу холбогдох төр төсвийн байгууллагуудад үүрэг чиглэл өглөө. Мөн 370 малчин, мал бүхий иргэд болон бизнесийн зориулалтаар газар ашиглуулахаар хадлан бэлтгэх гэрээ байгуулж, газар хуваарилалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд иргэд, олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг цахим сүлжээнд 17 удаа байршуулан, давхардсан тоогоор 725 хүний хандалтыг авсан байна. Мөн иргэд, малчид, тээвэрчдэд зориулан Орхон цаг уурын станцаас цаг агаарын урьдчилсан мэдээг 5 хоног тутам тогтмол хүргэж байна.

“Хөтөлийн Цемент Шохой” ТӨХК-ий хамтын ажиллагааны гэрээний дагуу “Нийгмийн хариуцлага”-ын хүрээнд Бэлэндалай багийн 42-р зөрлөг, Шийрийн бригадын чиглэлд 2.1 км замыг хайрган хучилт хийж, засаж сайжрууллаа.

Сумын нэгдсэн авто граж, агрегат засварын төвийн ажил 70 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн Дэнж, Сансар, Цагаан-Овоо гэсэн 3 хэсгийн худагт “Ухаалаг худаг”-ийн системийг 38.459,780 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “Баялаг говь” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэйгээр суурилуулж дууслаа. Мөн Цагаан-Овоо хэсгийн гүний худагт ус зөөлрүүлэгч байршуулж, 600 ширхэг усны картыг хүлээлгэн өгсөн.

Сумын хэмжээнд нийт 13423 га талбайд тариалалт хийснээс улаан буудай 6154 га, овъёос 60 га, арвай 10 га, тэжээлийн ургамал 718 га, тосны ургамал 5024 га, төмс 627 га, хүнсний ногоо 830 га талбайд тус тус тариалсан. Ургац тогтоолтын урьдчилсан балансаар улаан буудай 6154 га талбайгаас 8615 тн, га-ийн ургац 14 цн, тосны ургамал 5024 га талбайгаас 2009,6 тн, га-ийн ургац 4 цн, тэжээлийн ургамал 718 га талбайгаас 1292,4 тн, га-ийн ургац 18 цн, овъёос 60 га талбайгаас 96 тн, га-ийн ургац 16 цн, төмс 627 га талбайгаас 9405 тн, га-ийн ургац 150 цн, хүнсний ногоо 830 га талбайгаас 13280 тн, га-ийн ургац 160 цн-ээр байхаар тус тус тогтоогоод байна.

Үндэсний статистикийн “ХАА-7” цахим программд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 36 аж ахуйн нэгж, 105 иргэний тариалалтын мэдээг шивж орууллаа.

Намрын ургац хураалтын ажилд шаардлагатай нийт хүн хүчний буюу 431 оюутан цэргийн болон техникийн бэлэн байдлын судалгааг гарган холбогдох газар хүргүүлэн ажиллалаа.

Сант сүм:

2023 онд сумын хэмжээнд 9 аж ахуй нэгж, 91 иргэний улаан буудай-2557га, овьёос-388га, ногоон тэжээл-380га, тосны ургамал-1056га, төмс-141га, хүнсний ногоо-215,3 талбайн ургацыг урьдчилан тогтоолоо. Үүнээс:

-Улаанбуудай: 2557 га талбайгаас 4346,9 тн буюу нэгж га талбайгаас 17цн ургац

-Овьёос: 388 га талбайгаас 465,6 тн буюу нэгж га талбайгаас 12цн ургац

-Ногоон тэжээл: 380 га талбайгаас 570 тн буюу нэгж га талбайгаас 15цн ургац

-Тосны ургамал: 1056га талбайгаас 422,4 тн буюу нэгж га талбайгаас 422,4цн ургац.

-Төмс: 141 га талбайгаас 2115 тн буюу нэгж га талбайгаас 150 цн ургац

-Хүнсний ногоо: 215,3 га талбайгаас 3875,4тн буюу нэгж га талбайгаас 180цн байна.

Монгол улсын Засгийн газрын “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 279 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 03 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаврыг үндэслэн сумын мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлууллаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 331 иргэнд 1498 м.куб түлээ, 48 иргэнд 148 м.куб хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгож, ойн нөөцийн орлого 7.185.063, нөхөн сэргээлтийн зардалд 3.036.000, талбай тусгааралтын төлбөрт 732.000, улсын тэмдэгтийн хураамжид 635.500 төгрөгийн орлого тус тус төвлөрүүлээ. Иргэдийн түлээ бэлтгэлийн ажил 30 хувьтай явагдаж байна.

БНСУ-ын хөдөөгийн хөгжлийн газрын харьяа “Монгол Копиа” төвийн санхүүжилтээр ХААИС-ийн мал аж ахуй биотехнологийн сургуулийн багш Ж.Шинэхүүгийн удирдан хэрэгжүүлж буй “Монгол улсад ферментжүүлсэн багсармал тэжээл үйлдвэрлэлийн технолгийг нутагшуулах” төслийн баг 2 удаа ирж, төсөлд хамрагдсан 20 өрхөд ногоон тэжээл тариалах технологи, хадлан бэлтгэх, дарш хийх арга, махны үхрийн тэжээл, тэжээллэг чанар сэдвээр сургалт явууллаа. Төсөлд хамрагдсан 20 өрх тус бүрт дарш хийхэд нь зориулан нэг шуудай Ферментжүүлсэн багсармал тэжээл олголоо.

Мөн төсөлд хамрагдсан өрхөөс гадна 12 малчин өрхийн төлөөлөлд сүү цагаан идээг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах технологи, мал эмнэлэгийн сургалтуудыг зохион байгууллаа. Сургалтаар Монгол малын сүүгээр үйлдвэрлэлийн аргаар зөөлөн цагаан бяслаг, аарц, зөөхий үйлдвэрлэх болон шар сүүгээр цэлцэгнүүр, чихэр хийх сургалтуудыг газар дээр нь хийж үзүүллээ.

Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хүүхдүүдэд багаас нь боловсрол олгох зорилгоор УИХ-н гишүүн Ж.Эрдэнэбатын дэмжлэгтэйгээр сумын цэцэрлэг “Ёс заншлын өргөө” -тэй болсон байна.

Сайхан сүм:

Иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу Дөмбөн хорооллын цахилгааны эх үүсвэргүй айл өрхүүдэд цахилгааны шугам татах ажлыг сумын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хөтөл цэнэг” ХХК гүйцэтгэж дууссан. Энэхүү ажлын хүрээнд 18 ширхэг тулгуур шон, 12 ширхэг удирдлагын хайрцаг, кабелийн шугам татах зэрэг ажлууд хийгдэж, шинэ Дөмбөн хорооллын 34 айл өрхийн утас богиносож цахилгаан эрчим хүчний аюулгүй ажиллагааны найдвартай эх үүсвэр бий боллоо.

8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Төв талбайн шинэчлэл, засварын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Номгон тосгоны 12 айлын нийтийн орон сууцны дээврийн засварыг гүйцэтгэсэн. Уг ажлын хүрээнд сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох мембрам-н дээвэр, агааржуулагч хоолойнуудыг шинэчилж өрөх, угсрах ажлууд хийгдээд байна.

Хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан хамран сургах тойргийн хүрээнд нийт 326 хүүхдүүдийг харьяа цэцэрлэгүүддээ бүрэн хамруулж хамрагдалт 100 хувьтай байна.

Цэцэрлэгт хамрагдах 326 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт, шинжилгээнд хамруулах зорилгоор 8 дугаар сарын 28,29-ний өдрүүдэд цэцэрлэгийн байранд үзлэг шинжилгээ өрхийн эмч, шүдний эмч, лабораторийн хамт олонтой хамтран зохион байгууллаа. 1,2-р цэцэрлэгийн 207 хүүхдээс 191 хүүхэд шинжилгээнд хамрагдсан. Гүйцэтгэл 92,2 хувьтай байна. Хичээлийн жил эхлэхтэй холбоотойгоор 61 багш ажилчдыг аймгийн нэгдсэн эмнэлэгт үзлэг, шинжилгээнд 100 хувь хамруулсан.

“Сэлэнгэ ариутгал” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан дотор 1300 м.кв талбай, гадна 650 м.кв талбайд өдөр бүр ариутгал болон шавж устгал хийлгэсэн. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотор усны хайрцаг 4ш, галын хор 4 ширхэгийг авч тавьсан.

2023-2024 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг ханган сул орон тооны сонгон шалгаруулалтыг нээлттэй цахим группүүдэд байршуулж 3 удаагийн сонгон шалгаруулалтыг зарлан ажиллаж байна.

Хичээл сургалтын үйл ажиллагаанд бэлдэн “Сэлэнгэ Ариутгал” ХХК-тай хамтран 2561м² талбайд ахуйн шавж мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн.

Сүхбаатар сум:

Залуучуудын хөгжлийн үндэсний 9 дүгээр чуулган “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуусын бүтээлч оролцоо” уриан доор 8 дугаар сарын 25-ны өдөр төрийн ордонд зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газартай хамтран “Залуучуудын оролцоо” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг сумын залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн гишүүд, иргэдийн төлөөлөл, төрийн бус байгууллагын нийт 23 залуучуудыг оролцуулан зохион байгуулсан.

8 сард орсон түр зуурын аадар борооны улмаас тус сумын гудамж талбай, замууд эвдэрсэнтэй холбогдуулан холбогдох албан хаагчид үерийн далан, суваг шуудууны нөхцөл байдлыг шалгах ажлыг зохион байгуулж ажилласан. Сумын Онцгой комиссын 8 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар үер усны аюулаас үүссэн зам, гудамж талбайн эвдрэл гэмтлийг сэргээн засварлах, шуурхай авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргасан. Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд 1,3,4-р багийн 20 иргэдийг түр ажлын байраар ханган үерийн далан, гуу жалга, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэж хог хаягдлыг ачуулсан.

Түр зуурын усархаг бороонд хог хаягдал урсаж Салхит 3-р багийн үерийн далан, Баянхан 4-р багийн үерийн хамгаалалтын далан бөглөрч айл өрх, гудамж талбай үерийн усанд автсаныг шуурхай арга хэмжээ авч бөглөрсөн хог хаягдлыг зайлуулсан.

Тус сумын 8-н багийн гудамж талбайд нийт 58-н ховоо хайрга шороог буулгаж, ард иргэд болон экскаватороор тэгшлэх түрүүлэх ажлыг хийсэн.

Буурхээр 8-р багийн мал эмнэлэг, Гахайн байр орчмын замын үерийн усанд идэгдсэн хэсэгт хайрга шороо асган тэгшилж хаалт тавих болон буурын голын

эргийн дагуух үерт автсан, үер усны аюулд өртөж болзошгүй айлуудад хамгаалалтын зурвасыг хийж ажилласан.

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажилж амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд 150-н эзэнгүй, уяа хамгаалалтгүй золбин ноходыг устгах ажлыг зохион байгуулж, төвлөрсөн хогийн цэгт булшилж, хөл газрын ургамлын устгал хийх талаар аж ахуй нэгж, төр төсвийн байгууллагуудад чиглэл хүргүүлж ажиллалаа.

Сумын айл өрхийн хаягжуулалт хийх ажлын шинэчилсэн хаягийн тэмдэг тэмдэглэгээг "Геомет" ХХК суурилуулан, хүлээлгэж өгсөн.

Тус сумын Салхит 3 дугаар багийн 1-р хэсгийн гудамжны айл өрхүүд нэгдэж "Жишиг гудам" болох хөдөлгөөн өрнүүлэх ажлыг зохион байгуулснаар айл, өрх бүр үүдэндээ орчин үеийн мэдрэгчтэй гэрлүүдийг суурилуулж, гудамжныхаа зэрлэг ургамал, шарилж, хог хаягдал зэргийг цэвэрлэх ажил хийгдлээ.

Түшиг сум:

Тайлант хугацаанд санхүүгийн дэмжлэг төлөвлөгөө 332,030,4 мянган төгрөг , гүйцэтгэл 332,030,4 мянган төгрөг байна. Орон нутгийн байгууллагуудад 639,632.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож ажиллагаа.

Орон нутгийн орлого төлөвлөгөө 248,543,3 мянган төгрөг, гүйцэтгэл 217,190,0 мянган төгрөг буюу 87,3 хувийн биелэлттэй буюу 07 сарын байдлаар 12,7 хувиар тасарсан байна. Эхний хагас жилийн ТТЗахирагчийн санхүүгийн нэгтгэл тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргах шатандаа, 2024 төсвийн төсөл 2025,2026 оны төсвийн төсөөлөл хийсэн. Эрхэлсэн ажлын хүрээнд шилэн дансны хууль тогтоомжийн дагуу санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангаж байгууллагын цахим хуудсанд хууль заасан хугацаанд холбогдох мэдээллийг оруулж ажиллаж байгаа.

"ММЭ Түшиг" ХХК Улаалзганатын аманд нарс 200 м3 хэрэглээ, 70 м3 түлээ бэлтгэл, хяналтын хуудас, гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажилласан.

"Мойлт нуга" ХХК буйлаастын аманд 160 м3 нарс мод бэлтгэл, тээвэрлэлт, гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажиллаа. УБТЗ МБҮйлдвэрийн мод бэлтгэл, гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж орон нутгийн иргэдэд 130 м3 хэрэглээний мод худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавин ажиллаа. "Мойлт нуга" ХХК –ийн доод агуулахад тооллого хийсэн. 2023 онд агнах ан, амьтны тоо хэмжээг батлах тухай тогтоолын төсөл, хавсралтыг сумын ИТХуралд танилцуулж батлуулсан. УБТЗ МБҮйлдвэр мод бэлтгэлээс гарсан түлээний модыг орон нутгийн 35 өндөр настан, зорилтот бүлгийн айл өрхөд үнэ төлбөргүй буулгах ажлыг зохион байгуулсан. "ММЭ Түшиг" ХХК, "Мойлт нуга" ХХК-ийн 3 талбайд мод бэлтгэл болон гарал үүслийн гэрчилгээгээр гадагш тээвэрлэж байгаа модонд хяналт тавьж эрхийн бичиг, гарал үүслийг хянаж ажиллалаа.

Зөвшөөрөлгүй ан агнах, загас барихаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Замын карьер ашиглах, захын тэмдэгүүдийг тэмдэгжүүлж хяналт тавьж ажиллалаа.

Соёлын төв нь 08-р сард нийт соёл урлагийн болон нийтийг хамарсан 2 үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Номын санд нийт шинээр 6 уншигч карт нээлгэж байнгын 15 уншигч 23 уран зохиолын болон үлгэр, танин мэдэхүйн номоор үйлчилсэн.

Сумын ахмадын хороотой хамтран "НАМРЫН ӨНГӨ - 2023" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр ахмадуудынхаа дунд "Хөгжилтэй буухиа" тэмцээн, "Хослон дуулья" тэмцээн, "Монгол наадгай" шагайн 2 төрлийн тэмцээнийг зохион байгуулж ажиллалаа. "Түшиг ажнай" МСУХолбоотой хамтран 8 дугаар сарын 15-ны өдөр уяачдын баяраа Хавтгай овоонд тэмдэглэн өнгөрүүллээ. Хязаалан, Шүдлэн, Дааган насны морьдын уралдаан, үндэсний бөх, өсвөрийн бөхийн барилдаан болж үдшийн цэнгүүнээр баярын үйл ажиллагаа маань өндөрлөлөө.

Хушаат сум:

Жил бүр уламжлал болгон зохиогддог малчид, иргэдэд төрийн ажил үйлчилгээг сурталчлан таниулах, иргэдийг сонсох багийн өдөрлөгийг 8 сарын 17-19-ний өдрүүдэд Артойлбо, Өвөр хуурай чиглэлд зохион байгуулсан.

8-р сарын байдлаар 87 иргэн, 1 аж ахуй нэгжид мод бэлтгэх эрхийн бичиг авч 7,463,820 төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн байна.

Сумын ИТХ-ийн 2023 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бэлчээрийн газрыг фото мониторингийн аргаар үнэлэх ажлаар Шугуйт, Могойт, Бугатаар, 2023.08.08, 10-нд Бумбат тохой, Сээрийн гол, Хашаат, Нарс толгой, Ар сүүж, Бор толгой, Асмалжин, Могойт, Хуучин төв, Наран булаг Мөнхтолгой, Баянбулаг, Рашаант гэх байршлуудад Геодезын тэг тэмдэгтийн тооллогын ажлаар явж ажилласан. Мөн хадлангийн зориулалтаар газар ашиглах хүсэлтэй 40 иргэнтэй гэрээ байгуулж ажиллалаа.

Сумын газар тариалангийн ургац тогтоолтын ажил 60 хувьтай хийгдэж байна.

Хүдэр сүм:

Аймгийн хөдөө аж ахуйн газарт хадлангийн техник болон өвөлжих малын судалгааг гаргасан ба газар тариалангийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгж, 30 иргэний трактор 32, чиргүүл 32, хадуур 32 тармуур 27, преслэгч 8, нийт 131 техник хэрэгслийг бүртгэж ажилласан. Сумын 154 малчин өрх болон 230 мал бүхий өрхөөс өвөлжих малын судалгааг авсан ба нийт 39290 мал бүртгэгдсэн байна.

Малчдын саналаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Шанд болон Уялгын чиглэлд 52,0 сая төгрөгөөр мал угаалгын ванныг хийж гүйцэтгэсэн.

Ерөө суманд зохион байгуулсан Суффолк үүлдэрийн хонины эх сүргийн аж ахуйтай танилцах өдөрлөгт сумын харьяат 3 малчинг хамруулан ажиллалаа.

МЭНС-2.0 шинэчлэгдсэн хувилбараар тайлант сард 28 удаагийн гэрчилгээг баталгаажуулж иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаа. Үүнд: Адуу 4 толгой, үхэр 23 толгой, хонь 162 толгой, ямаа 82 толгой, гахай 2 толгой, үхрийн мах 440 кг, хонины мах 207кг, ямааны мах 22кг, гахайн мах 80кг нийт 749кг, тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавьж ажилласан.

Малын гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйл ажиллагаанд технологийн хяналт хийх “Шалгах хуудас”-ны дагуу сумын Тарвагатай, Баянцагаан багуудын малчин өрхүүдэд хяналт шалгалт хийж Баруун Шанд, Зүүн Шанд, Дулаан-Энгэр, Шивэрт, 16 даваа, Сөдтэй, Шаврын булаг гэх чиглэлд, хөдөөгийн 10 малчин өрхийн суурьт орж Шалгалтын хуудсаар дархлаажуулалтын технологийн хяналт хийж ажиллалаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 1 дуудлага мэдээллийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, гэр бүлд эргэн нэгдсэн бага насны хүүхдэд хяналт тавих зорилгоор Гэр бүл хүүхэд хамгааллын хамтарсан багийн 3 гишүүн 2 удаа гэрээр сэтгэл заслын үйлчилгээг үзүүлж ажилласан.

Нийгмийн халамжийн 9 төрлийн үйлчилгээнийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, нийт 7,427,900 мянган төгрөг олгож ажиллаа. 7 дугаар сард хүүхдийн мөнгө нөхөн олгосонтой холбоотой Сангийн яамнаас хамаарч сумын 31 хүүхдийн 3,100,000 төгрөгийн олголт давхар үүсч, иргэдийн данс руу шилжсэнийг иргэн тус бүрт мэдээлсэн.

Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтыг Шоргоолж, Монгол алт чиглэлд 3 удаа хийж, Цагаан Зүрийн гол дагуу зохих зөвшөөрөлгүй хууль бусаар техник хүн хүчээ төвлөрүүлсэн 8 иргэнийг бүртгэлжүүлэн техник хэрэгсэлээ татан буулгах тухай Албан мэдэгдэл өгсөн.

Төмрийн хүдэр олборлох ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Дархан төмөрлөг” ТӨХК, “Эрдэс групп” ХХК-иудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2

удаа хийсэн. Хяналт шалгалтын явцад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай хугаацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Хүдэр сумын Засаг даргын 2022 оны А/142 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан сумын хэмжээнд уул уурхайн олборлолтод өртөж эвдэгдсэн бичил уурхайгаар ашиглах боломжтой газрын байршлыг тогтоож ажлыг 8 сард гүйцэтгэж нийт 55.5 га талбайн хэмжилт хийж цэг солбилцлийн судалгааг гарган ажилласан.

Ойн дагалдах баялаг ашиглах эрх бүхий “Оргих наран булаг” ХХК, “Арвин ачит” ХХК, “Нэмүүн тайга” ХХК-иуд нь нийгмийн хариуцлагын хүрээнд хушин ойг нөхөн сэргээх, үрийн плантаци байгуулах зорилгоор хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 121,6 сая төгрөгийн санхүүжилтээр Ойн ангийн өмчийн мод үржүүлэгийн газарт нэн шаардлагатай байгаа хөрс боловсруулах жижиг оврын мини экскаватор, цахилгаан үүсгүүр авч, сургалтын танхим, боргоцой цех, үрийн агуулах барьж ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг аялал зугаалгаар зорчиж яваа 10 тээврийн хэрэгсэл, 36 иргэнд сурталчлан таниулж ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт байршуулахыг анхааруулж ажиллалаа. Иргэдийн гомдол мэдээллийн дагуу ойн мэргэжлийн байгууллагын 3 хөрөө рамыг лацдсан.

Нийт эмчийн үзлэг 302 хийгдсэнээс 71 буюу 23,5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 167 буюу 55,2 хувийг өвчний учир амбулаторт, 41 буюу 13,5 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 23 буюу 7,6 хувийг гэрийн үзлэг эзэлж байна.

Амбулаторийн 302 үзлэгийн 36,1 хувийг их эмч, 32,6 хувийг эх баригч, 31.3 хувийг бага эмч үзлэг хийж оношлогоо эмчилгээг шийдвэрлэсэн байна.

2023 оны 08 сард 101 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилснээс 5 буюу 4.9 хувийг алсын дуудлага 1.6 хувийг осол, гэмтлийн дуудлаганд үйлчилсэн. Хүлээн авах яаралтай тусламжийн тасагт 33 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн. Хэвтүүлэн эмчлэх тасагт 23 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 218 ор хоног ашигласан байна.

Шаамар сум:

Ургацын урьдчилсан баланс тогтоох ажлын хүрээнд нийт 3289 га талбайгаас 9995 тн ургац хураан авахаар тоологдож үерийн улмаас 13 га талбай ургац алдсан байна. Ургац тотоолоор явж байх хугацаанд 47 га талбайд тариалалт хийгээгүй байгаа нь шалгалтын явцад илэрсэн.

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 2.321.100 төгрөгийг төвлөрүүлсэн.

8 дугаар сард Суффолк үүлдрийн хонины эх сүргийн үржлийн аж ахуйн танилцуулга өдөрлөгт Дулаахан тосгоны малчныг оролцуулсан.

Мах сүүний чиглэлийн СИМЕНТАЛ, АПАТАУ, МАХНЫ чиглэлийн АНГУС ЛИМУЗИН Үүлдрийн бухын үрээр 100 үхэрт ЗОХИОМОЛ хээлүүлэгийн ажил хийсэн.

“Монгол ЛЗ зам гүүр” ХХК-ийн 2 жолооч хориглосон хэрэглэслээр зөвшөөрөлгүй загас агнаж байсныг илрүүлж Зөрчлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч торыг хураан авч ажилласан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд сумын Засаг даргын А/102 тоот захирамж гарсантай холбогдуулан галын түлээ бэлтгэх гэрээ, эрхийн бичгийг 24 иргэнд 120 м3 галын түлээг олгон ажиллаж байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР